

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН
АМНЫ ХӨНДИЙ, НҮД, СОНСГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.НОМИН-ийн
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|--|--|--|--------------------------------------|--|---|--------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. АМНЫ ХӨНДИЙ, НҮД, СОНСГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 “Эрүүл Шүд” арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-ний хэрэгжилтийг хангах | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь /40%/ | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь 20% | 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны хэрэгжилт 20%-д хүрсэн байна | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27/А25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө”-г 2024-2027 онд хэрэгжүүлэхээр баталж, 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус арга хэмжээний хэрэгжилтийн хувь 40%-тай. Үүнд: Зорилт 1-ийн хүрээнд: - Хяналт, мэдээллийн системийг эрүүл мэндийн салбар, боловсролын салбар дата солилцох, оруулах, хянах үйл ажиллагааг зохицуулсан eruulshud.mn цахим системийг бий болгосон. Илрүүлгийн явцыг хянах, мэдээлэл авах зорилгоор нийслэлд дашборд | 2025.01-06.10 | 100% |

| | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|
| | | | | | <p>https://eruulhuuhed.mn/mainDashboard ба аймаг орон нутгийн дашбоардыг ашиглаж эхэлсэн https://aimag.eruulhuuhed.mn/mainDashboard/2</p> <ul style="list-style-type: none"> - "Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, аймаг/нийслэлийн эрүүл мэндийн газар, шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/70 тушаалаар батлуулсан. <p>Зорилт 2-ийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн боловсрол олгох "Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдүүддээ юу бэлэглэхээ эргэн харах, тус өдрийг угтан хүүхдийнхээ шүдийг үзүүлж, эмчлүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах" зорилготой "Бэлгээ бэлдье" аяныг зохион байгуулсан. - 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ"-ний хүрээнд нийслэлийн хэмжээнд 69,445 хүүхдийг шүдний эрт илрүүлгийн үзлэгт хамруулсан. - Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 сарын 11 өдрийн 6/1171 | |
|--|--|--|--|--|---|--|

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>удирдамжийн дагуу 24/3 Шүдээ зөв угаа 2025 аяны хүрээнд шинээр байгуулсан шүд угаах цэгийн тоо 36 нэмэгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 сарын 11 өдрийн 6/1171 удирдамжийн дагуу 24/3 Шүдээ зөв угаа 2025 аян зохион байгуулагдсан. - Азийн хөгжлийн банкны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд “Номадик контент ХХК”-тай хамтран эрүүл шүдний ач холбогдол, шүд угаах, эмчид үзүүлэхийн ач холбогдлын тухай бичлэгийг хийлгэж ЕБС-ийн сурагчдад цахим хэлбэрээр тараасан. - “Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ”-ний хүрээнд улсын хэмжээнд нийт 69,445 хүүхдийг шүдний эрт илрүүлгийн үзлэгт хамруулсан ба урьдчилан сэргийлэх фторт түрхлэгийг түрхсэн. - Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/53, А/37 дугаар тоот тушаалын хүрээнд Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөө /2025-2028/ батлах | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>тухай тушаалын шалгуур үзүүлэлт 8, 16 Зорилт 4-ийн хүрээнд шүд угаах орчин бүрдүүлэх тухай нэмэлтээр саналыг тусган батлуулсан.</p> <p>Зорилт 3-ын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн сурагчдад шүдний эрт илрүүлэг хийх эмч, эмчийн туслахыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 25,26-ны өдөр нийт 260 эмч, эмчийн туслахыг хамруулан зохион байгуулав. - "Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар"-ын төслийн хэлэлцүүлгийг ЭМЯ-ны Б зааланд 2025 оны 4-р сарын 24-ний өдрийн 14:00-17:30 цагийн хооронд нүүр ам судлалын салбарын болон халдвар хамгааллын чиглэлийн эмч мэргэжилтэн нийт 70 хүнийг хамруулан зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган https://moh.gov.mn/news/7312 вэбсайтад нэмэлтээр санал авахаар байршуулсан. <p>Зорилт 4-ийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|--|
| | | | | | <p>хэмжээ"-ний хүрээнд 149 АШЭМБ-тай хувийн хэвшлийн шүдний эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдтэй гурвалсан гэрээг байгуулуулан хамтран ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ"-ний хүрээнд 149 АШЭМБ-тай хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй хамтран 1 дүгээр ангийн суралцагчдад эрт илрүүлгийг зохион байгуулан фторт түрхлэг түрхэх, сийланта түрхлэг тавих ажлыг зохион байгуулав. ЭМДС-аас шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт 1,890,085,964 төгрөгийг 53,309 хүүхдийн үзлэгт зарцуулав. - Чингэлтэй Дүүргийн СӨБ 19, 39, 43, 102, 224, 277, 280, 293 дугаар цэцэрлэгүүд дээр хүүхдийн үзлэгийн эмнэл зүйн иж бүрэн тоноглогдсон шүдний кабинетын үйл ажиллагааг эхлүүлж 2 цэцэрлэг дээр эрүүлжилтийн ажлыг амжилттай зохион байгуулсан. - - Багш хүмүүжүүлэгч, эцэг эх асран хамгаалагчид, 2-5 насны хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох тусгай ерөөг бэлтгэн ашиглалтад оруулж, нийт 110 багш ажилчдад онолын | | |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>болон гардан үйлдлийн хичээл заасан</p> <ul style="list-style-type: none"> - Чингэлтэй Дүүргийн СӨБ 19, 39, 43, 102, 224, 277, 280, 293 дугаар цэцэрлэгүүд дээр 2-5 насны 8 цэцэрлэгийн 72 бүлгийн нийт-1206 хүүхэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Үүнээс: Эрүүл 155 хүүхэд, цооролтой 1050 хүүхэд, цооролтой шүдний тоо 6473, цоорлын улмаас авхуулсан шүдний тоо 53, эмчлүүлсэн шүдний тоо 1121, ЦЛА шүдний тоо 7702, Шүд цоорох өвчний тархалт 84%, Цоорлын эрчим 6,5 шүд байв. <p>Зорилт 5-ын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтын иж бүрэн тоноглогдсон автомашин Эрт илрүүлэг 1 арга хэмжээний хүрээнд үйлчилгээ үзүүлж эхэлсэн ба нэмэлтээр ХУД-ийн алслагдсан бүсийн 10,159,59,-р ерөнхий боловсролын 5-р ангийн 113 хүүхдүүдэд явуулын үзлэгийн шүдний бүрэн тоноглогдсон машинаар ХУДЭМТ-тэй хамтран зохион байгуулсан. - Нийт 69,447 хүүхэд шүдний үзлэгт хамрагдаж нийслэлийн хэмжээнд эрүүлжүүлэлт 40%-тай, орон нутгийн хэмжээнд шүдний эрүүлжүүлэх үйл ажиллагаа 93%-тай үргэлжилж байна. | | |
|--|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <ul style="list-style-type: none">- Бүгд Найрамдах Солонгос Улсад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад болон анхан шатны байгууллагуудад шүдний эрт илрүүлгийн үзлэгийг дижитал технологи ашиглан хэрхэн хэрэгжүүлж буй туршлага судлах, танилцах уулзалтад ТНБД-ын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн гадаад уулзалтад оролцох тухай тушаалын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрүүдэд туршлага судлан ирсэн ба тус дижитал технологийг хэрэглээг туршилтын журмаар нэвтрүүлэхээр төлөвлөлтийг зохион байгуулахаар ажиллаж байна.- Хөвсгөл аймгийн ЭМГ-ын шүдний кабинетад дэлгэмэл рентген зураг шинээр шийдвэрлэсэн. Орон нутгийн сонгогдсон 30 сумдуудад 300,000\$ ам долларын үзлэгийн сандлыг санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сангаас шийдвэрлэхээр ажиллаж байна.- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дугаар тогтоолоор хүүхдийн шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний багцыг шинээр бий болсонтой холбогдуулан уг тусламж үйлчилгээг зохицуулсан | | |
|--|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|----|--|-----------------------------|---|-------------------------------------|--|---------------|-----------|
| | | | | | <p>ба 2025 оны 6 дугаар сарын байдлаар шүдний эмчилгээнд 57,187 хүүхэд хамрагдаж 3,221,093,972 төгрөг, шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт 53,309 хүүхэд 1,890,085,964 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Зорилт 6-ийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Эрүүл шүд- эрүүл ирээдүй” нүүр ам судлалын салбарын II зөвлөгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2025 оны 03 сарын 20,21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын удирдамж, хөтөлбөрийг Эрүүл мэндийн сайдаар батлуулж зохион байгуулалтын ажлыг хангаж салбар бүрийн төлөөлөл болох нийт 500 оролцогчийг хамруулан зохион байгуулав. | | |
| 2. | <p>Арга хэмжээ 1.2</p> <p>Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар батлуулах</p> | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12-р сарын 9-ны өдрийн А/490 дугаар тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг | Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна | <p>“Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар”-ын төслийн хэлэлцүүлгийг ЭМЯ-ны Б зааланд 2025 оны 4-р сарын 24-ний өдрийн 14:00-17:30 цагийн хооронд нүүр ам судлалын салбарын болон халдвар хамгааллын чиглэлийн эмч мэргэжилтэн нийт 70 хүнийг хамруулан зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган 5 дугаар сарын 22-ны өдөр https://moh.gov.mn/news/7312 вэбсайтад нэмэлтээр санал авахаар байршуулсан.</p> | 2025.01-04.24 | 100% ✓ |

| | | | | | | | |
|----|---|------------------------------------|---|--|---|------------------|---------------------------------|
| 3. | Арга хэмжээ 1.3 Амны хөндийн эмгэгээс урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний удирдамж батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Зааврын төсөл 70%-тай | Тушаалын төсөлд санал авсан байна | ЭМЯ-ны НАСМСЗ, Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбооноос саналын авч нэмэлт өөрчлөлтийг оруулан тушаалын төслийг тойруулж эхлэв. | 2025.01-06 | 100% |
| 4. | Арга хэмжээ 1.4 Анхан шатны эрүүл мэндийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн төвүүд шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан ажиллах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна | “Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, аймаг/нийслэлийн эрүүл мэндийн газар, шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/70 тушаалаар батлуулсан. | 2025.01.01-03.07 | 100% |
| 5. | Арга хэмжээ 1.5 ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчдыг нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэгт хамруулах | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024 оны 01 сарын 19-ний А/27А/25 дугаар тушаал | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо <i>Урсгилт нүд нь мэдэгдсэн хүүхдүүд</i> | Нийслэлийн ЕБС-ийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 40,753 хүүхдийн 89.69% нь хамрагдсан байна. Шүд цоорох өвчин 90%, харааны өөрчлөлт 20.4% -д тус тус илэрсэн. Орон нутгийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 38,723 хүүхдийн 98.5% нь хамрагдсан байна. Үүнээс шүдний илрүүлэгт 91.6% орж, нүдний илрүүлэгт 84.2% хамрагдсан https://aimag.erulehuuhed.mn/mainDashboard/2 https://erulehuuhed.mn/mainDashboard/1 | 2025.01-06 | 100% <i>сидмал оролцогч?</i> |
| 6. | Арга хэмжээ 1.6 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн 1 дүгээр | Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын | Нийслэл, аймгийн ЕБС-ийн 1 дүгээр ангийн | Нийслэлийн ЕБС-ийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 40,753 хүүхдийн дараагийн шатны оношилгоо, эмчилгээний явц нүд | 2025.01 | 100% |

Урсгилт нүд нь мэдэгдсэн хүүхдүүд
а/р/рэх нүд

| | | | | | | | |
|----|---|--------------------------------|---|--|--|---------------|-------------|
| | ангийн суралцагчдыг нүд, шүдний эмчилгээнд хамруулах | | хамтарсан 2024 оны 01 сарын 19-ний А/27А/25 дугаар тушаал | хүүхдүүдийг эмчилгээнд хамруулсан байна | 17%-тай, шүд 41%-тай явж байна. Орон нутгийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 38,723 хүүхдийн 92% нь шүдний 2 дугаар шатны эмчилгээнд хамрагдаж, 4.32% нь нүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдаж эмчлүүлээд байна. https://aimag.eruulhuuhed.mn/mainDashboard/2 https://eruulhuuhed.mn/mainDashboard/1 | | |
| 7. | Арга хэмжээ 1.7 Амны хөндийн эмгэгийн илрүүлэг, оношилгоонд дижитал технологийн хэрэглээ, инновац нэвтрүүлэх | Инновацыг нэвтрүүлсэн байна | - | Инновац, дижитал технологийн хэрэглээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна | “Эрүүл шүд” арга хэмжээний зорилтыг хангаж ажиллахын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад болон анхан шатны байгууллагуудад шүдний эрт илрүүлгийн үзлэгийг дижитал технологи ашиглан хэрхэн хэрэгжүүлж буй туршлага судлах, танилцах уулзалтад ТНБД-ын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн гадаад уулзалтад оролцох тухай тушаалын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрүүдэд туршлага судлан ирсэн ба тус дижитал технологийг хэрэглээг туршилтын журмаар нэвтрүүлэхээр төлөвлөлтийг зохион байгуулахаар ажиллаж байна. | 2025.03-06.10 | 100% 20% |
| 8. | Арга хэмжээ 1.8 Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулах | Зохион байгуулагдсан зөвлөгөөн | НАС-ын анхдугаар зөвлөгөөн | НАС-ын зөвлөгөөн зохион байгуулсан байна | “Эрүүл шүд- эрүүл ирээдүй” нүүр ам судлалын салбарын II зөвлөгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2025 оны 03 сарын 20,21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнийг зохион байгуулах | 2025.03.-04 | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|---|---|--|--|------|
| | | | | | ажлын удирдамж, хөтөлбөрийг Эрүүл мэндийн сайдаар батлуулж зохион байгуулалтын ажлыг хангаж салбар бүрийн төлөөлөл болох нийт 500 оролцогчийг хамруулан зохион байгуулав. | | |
| 9. | <p>Арга хэмжээ 1.9</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүд цоорох өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, нүүр амны тусламж үйлчилгээний аргачлалын удирдамжийг боловсруулах, нэвтрүүлэх</p> | Тусламж үйлчилгээний удирдамжийг боловсруулж, суурь судалгааг хийсэн байна | - | | <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүд цоорох өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх удирдамжийг боловсруулсан байна</p> <p><i>Баттуулсан</i></p> | 2025.05-06 | 70% |
| 10. | <p>Арга хэмжээ 1.10</p> <p>Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл Монгол хүн" арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөөнд "Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулах</p> | Чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэлэлцүүлэн, батлуулсан байна | 2024-2027 "Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө | Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | <p>ЭМС-ын 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/64 дугаар тоот ажлын хэсэг батлах тушаал, ТНБД-ын баталсан ажлын хэсгийн төлөвлөгөөний хүрээнд Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл Монгол хүн" арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөөнд "Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дэд ажлын хэсгийг ахлан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. Тус үйл ажиллагааны төслийг чиглэл бүрээр мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн саналыг тусган ажлын хэсгийн нарийн</p> <p><i>Хэлэлцүүлсэн</i></p> | <p><i>а/о</i></p> <p>2025.03-06</p> <p><i>Хэлэлцүүлсэн??</i></p> | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|---|---|--|------------|------------------|
| | | | | | дарга, нарийн бичиг, зөвлөхүүдэд хүлээлгэж өгсөн. | | |
| 11. | Арга хэмжээ 1.11 Нүүр амны эмчилгээний удирдамж, зааврыг шинэчлэн батлуулах | Нүүр амны эмчилгээний удирдамж, заавар батлуулсан байна | Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/143 дугаар тоот тушаал, MNS 5372-2004 | - | - | 2025.06-12 | Хугацаа болоогүй |
| 12. | Арга хэмжээ 1.12 Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдийн харааг оношлох арга аргачлалыг нутагшуулах, эмч нарыг чадавхжуулах | Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдийн харааг оношлох арга аргачлалыг нутагшуулах, эмч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах | - | Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдийн харааг оношлох арга аргачлалыг нутагшуулах сургалтыг зохион байгуулах | Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдийн харааг оношлох арга аргачлалыг нутагшуулах, сурагчдад нүдний эрт илрүүлэг хийх эмчийг чадавхжуулах сургалтын удирдамжийн дагуу нүдний рефракцийн нарийн мэргэжлийн эмчийг хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээт суралцагчдын эрт илрүүлэгийн үзлэгийг нутагшуулах бэлтгэх зорилгоор гардан, онол, хэлэлцүүлэг хэлбэрээр бэлтгэж, чадавхжуулсан. Тус сургалтыг Орбис ОУБ-ын сургагч багш, эмч нар болон Брюс Мур (Bruce Moore), О.Д. (Нью-Ингландын Нүдний Шинжлэх Ухааны Коллежийн хүндэт профессор, Хүүхдийн нүдний эмч (оптометрист), "Сургуулийн өмнөх насны хүүхдийн хараа" (VIP) судалгааны үүсгэн байгуулагч, тэргүүлэх судлаач, АНУ-ын Хүүхдийн Хараа ба Нүдний Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн үүсгэн байгуулагч гишүүн, Үндэсний шинжээчдийн зөвлөлийн гишүүн, Техникийн үнэлгээний дэд хорооны дарга, Массачусетс мужийн | 2025.05-06 | 100% |

| | | | | | | | |
|-----|---|----------------------------------|--------------------------------------|--|---|---------------|------|
| | | | | | "Хүүхдийн хараа" эвслийн дарга хамтран зохион байгуулсан. Тус үйл ажиллагааны хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 30-ний хооронд 70 дугаар тусгай сургууль, Орбис ОУБ-ын байранд нийт 70 хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хамруулан гардан үзлэг хийсэн ба үүнээс 55% нь нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдах шаардлагатай байна. Нийт 41 эмч нарыг нүдний рефракцийн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулсан. | | |
| 13. | Арга хэмжээ 1.13 Ахмадын амны хөндийн эрүүл мэндийн дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулагдсан арга хэмжээ | - | Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулан, тайлан, зөвлөмжийг гаргасан байна | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад настны үзлэг"-ийг 2025 оны 02, 03 дугаар сард зохион байгуулах ажлын хүрээнд ахмад настнуудад амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, уруулын булчингийн хүч, залгилтын сорилыг хийж үйлийн хямралтай гарсан ахмад настнуудад хүрч ажиллав. Үүнээс нийт ахмадуудад 100%-ийн шүд цоорох өвчний тархалттай шүд цоорох өвчний эрчмийн үзүүлэлт 18.3-23.15 ЦЛА/шүдний үзүүлэлттэй байв. | 2025.02-03 | 100% |
| 14. | Арга хэмжээ 1.14 "Улаанбаатар хотын 9 дүүрэг болон бүс нутгийн хотын нийт 14 улсын сургуулиудын 1-5 дугаар ангийн сурагчдын шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх | Зохион байгуулагдсан арга хэмжээ | Чингилтэй дүүргийн 37, 50 дугаар ЕБС | Анхан шатны уулзалтыг зохион байгуулах, ажлын төлөвлөгөөг боловсруулах | ЭМЯ, Жайка ОУБ, Япон дахь Эрүүл хотыг дэмжих байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Өвсний үндэс ТББ, Эрүүл хотуудын сүлжээ ТББ-ын хамтарсан "Улаанбаатар хотын 9 дүүрэг болон бүс нутгийн хотын нийт 14 улсын сургуулиудын 1-5 дугаар ангийн сурагчдын шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх төсөл"- | 2025.03.21-06 | 100% |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | төсөл"-ийг Жайка ОУБ, Өвсний Үндэс ТББ, бусад холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | | | | ийн хүрээнд сар бүр цахим уулзалтыг зохион байгуулан ажлын урьдчилсан хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулна. Салбар бүрийн оролцоог хангахын хүрээнд ЭМЯ-ны 2025-5212 дугаар албан бичгээр ирсэн хүсэлтийн дагуу ЭМЯ-ны холбогдох удирдлагуудтай уулзалтыг товлон цаашдын боловсруулсан хамтын ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах уулзалтыг 6 дугаар сарын 23-ны өдөр товлосон. | | |
|--|--|--|--|--|--|--|--|

ЗОРИЛТ 2. АМНЫ ХӨНДИЙ, НҮД, СОНСГОЛЫН ЭМГЭГИЙН ТАНДАЛТ, СУДАЛГААНЫ НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ

| | | | | | | | |
|-----|--|---|------------------------------|---|--|------------|------|
| 15. | Арга хэмжээ 2.1 ЕБС-ийн нүд, шүдний эрүүл мэнд, шүд цоорох өвчний хяналт, тандалтыг боловсронгуй болгох | Аймаг, нийслэлийн ЕБС-ийн эрт илрүүлгийн нүд, шүдний тоо мэдээний үзүүлэлтийг боловсронгуй болгох, үр дүнгийн нэгдсэн боловсруулалт гаргасан байх | Нийслэлийн дашбоард үзүүлэлт | Аймгийн дашбоард үзүүлэлт <i>Оюуцаг Сагверүү</i> | 2024 оны хүрээнд нийслэлийн хүрээнд шүд, нүдний дашбоард үзүүлэлтээс үзлэгийг хянах боломжтой байсан бол аймаг орон нутаг үзэх боломж бүрдээгүй байсан. 2025 оны 4-р сараас орон нутгийн үзлэг эхэлсэн ба тус үзлэгийн хүрээнд цахимд эмчилгээний хэсэг болон зарим сайжруулалтыг оруулсан. Тус ажлын үзүүлэлтийг https://aimag.eriulhuuhed.mn/mainDashboard дараах дашбоард сайтаас харах боломжтой. | 2025.02-04 | 100% |
|-----|--|---|------------------------------|---|--|------------|------|

ЗОРИЛТ 3. НЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, САЙН ДУРЫН АЖИЛТНЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НӨЛӨӨЛЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ

| | | | | | | | |
|-----|--|-----------------------------|---|---|---|------------|------------------|
| 16. | Арга хэмжээ 3.2 НЭМТҮ-нд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журам | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | - | - | 2025.06-12 | Хугацаа болоогүй |
|-----|--|-----------------------------|---|---|---|------------|------------------|

ЗОРИЛТ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ

| | | | | | | | |
|---|--|-----------------------------|--|--|--|---------------|------|
| 17. | Арга хэмжээ 4.1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны тэргүүлэх чиглэл батлах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/396 дугаар тоот тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаал батлуулсан байна | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын сарын 31-ний өдрийн "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны тэргүүлэх чиглэл батлах тухай" А/100 дугаар тоот тушаалаар нийгмийн эрүүл мэндийн төсөл арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг батлуулсан. | 2025.01-03.31 | 100% |
| ЗОРИЛТ 5. ХАРИУЦСАН АСУУДЛААР ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ | | | | | | | |
| 18. | Арга хэмжээ 5.1. Орон нутгийн нүүр амны эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалтын удирдамж | - | Сургалтын удирдамжийг батлуулсан байна. | Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн сурагчдад шүдний эрт илрүүлэг хийх эмч, эмчийн туслахыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 25,26-ны өдөр нийт 260 эмч, эмчийн туслахыг хамруулан зохион байгуулав. | 2025.03 | 100% |
| 19. | Арга хэмжээ 5.2 Орон нутгийн нүдний эрт илрүүлэг хийх эмч, мэргэжилтнүүд, ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалтын удирдамж | - | Сургалтын удирдамжийг батлуулсан байна. | Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн сурагчдад шүдний эрт илрүүлэг хийх эмч, эмчийн туслахыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 25,26-ны өдөр 21 аймгийн нүдний нарийн мэргэжлийн эмч, эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, боловсролын газрын мэргэжилтэн нийт 63 хүнийг хамруулан зохион байгуулав. | 2025.03 | 100% |

! - 1 үйл ажиллагаа - үүнийг хариуцсан хүн
- раш барр олгох
- сургалт - удирдамж
- сургалт 1/8-дээ.

Зурагцаа

| | | | | | | | |
|-----|---|---|---------------------------------|---------------------|---|---------------|------------------|
| 20. | Арга хэмжээ 5.3 Нүүр амны тусламж, үйлчилгээний халдвар хамгаалал, чанар аюулгүй байдлын сургалт | Чадавхжуулсан эмч, мэргэжилтнүүдийн тоо | - | - | - | 2025.06-12 | Хугацаа болоогүй |
| 21. | Арга хэмжээ 5.4 Шүдний эмч нарыг чадавхжуулах зорилгоор гадаадад/дотоодод туршлага судлуулан сургах эмч нарыг чадавхжуулах | Гадаадад/дотоодод сургалтад хамруулсан байх | - | - | - | 2025.06-12 | Хугацаа болоогүй |
| 22. | Арга хэмжээ 5.5 Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих олон нийтэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах аян өрнүүлэх "24/3 Зөв угаа" | Арга хэмжээ, аян өрнүүлэх, зохион байгуулах | 2024 он Эрүүл шүд-Эрүүл бие аян | Аян өрнүүлсэн байна | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 сарын 11 өдрийн 6/1171 удирдамжийн дагуу 24/3 Шүдээ зөв угаа 2025 аяны хүрээнд: - Шүдний урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх оношилгоо үзлэгт хамрагдсан нийт иргэд-196.658, эрдэсжүүлэлт хийлгэсэн хүүхдийн тоо-173.449 - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд өдрийн цайны дараа Шүд угаах цагийг хэрэгжүүлдэг болсон –Хан уул дүүрэг, Булган аймаг 12 цэг, Архангай-16 цэг, Дорноговь, Төв аймаг, Чингэлтэй дүүргүүд 4 цэг өдрийн хоолны дараа шүд угаах тогтмол цэгүүдтэй болсон байна. Нийт 102 цэг | 2025.03.20-06 | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|---|---|--|------------------|------|
| | | | | | <ul style="list-style-type: none"> - Амны хөндийг эрүүлжүүлсэн 5-12 насны хүүхдүүдийн тоо- 59,412 - Жирэмсэн эмэгтэйчүүдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэг – 3279 - Ахмад настны амны хөндийн эрүүл мэнд- 3932 - Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүсийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэг - 2074 | | |
| | | | | | <p>Эрүүл мэндийн яамны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн боловсрол олгох “Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдүүдээ юу бэлэглэхээ эргэн харах, тус өдрийг угтан хүүхдийнхээ шүдийг үзүүлж, эмчлүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах” зорилготой “Бэлгээ бэлдье” аяныг зохион байгуулсан.</p> <p>Арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдүүдийг амны хөндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн анхан шатны үнэлгээ хийж, явуулын шүдний эмчилгээнд хамруулсан - Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор зөв хооллолт, шүдний арчилгаа, сахрын хэт их хэрэглээний хор хөнөөлийн талаар мэдээлэл өгсөн - Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Эрүүл хүүхэд – Эрүүл | | |
| 23. | <p>Арга хэмжээ 5.6</p> <p>Амны хөндийн эмгэг үүсгэгч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах санаачилгыг дэмжих, иргэдэд чиглэсэн аян өрнүүлэх: “Бэлгээ бэлдье” сахрын хэрэглээг бууруулах аян</p> | <p>Аяны удирдамж, хамрагдсан хүүхдийн тоо, цахим идэвхжүүлэлт</p> | - | <p>Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд 1 сарын аян өрнүүлсэн байна</p> | <ul style="list-style-type: none"> - Хүүхдүүдийг амны хөндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн анхан шатны үнэлгээ хийж, явуулын шүдний эмчилгээнд хамруулсан - Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор зөв хооллолт, шүдний арчилгаа, сахрын хэт их хэрэглээний хор хөнөөлийн талаар мэдээлэл өгсөн - Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Эрүүл хүүхэд – Эрүүл | 2025.05.01-06.01 | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|---|---|---|--|------------------------------|
| | | | | | <p>ирээдүй” сургалт зохион байгуулж, хүүхдээ тогтмол үзлэгт хамруулахын ач холбогдлыг таниулсан</p> <p>- “Жишиг бэлэг” санал болгож, эрүүл мэндэд хоргүй, хөгжлийг дэмжих бэлэг бэлтгэх санаачилгыг дэмжсэн</p> <p>Тус үйл ажиллагааны хүрээнд алслагдсан дүүргийн 2000 гаран хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг хийж хэрэгжүүлсэн. Тус аяны мэдээллийг тогтмол ЭМЯ-ны болон НЭМҮТ-ийн цахим сүлжээ болон EAGLE телевизээр сурталчлан ажилласан.</p> | | |
| 24. | <p>Арга хэмжээ 5.7</p> <p>Ажлын байранд суурилсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж “Шүд угаах цаг”-ийг хэрэгжүүлэх</p> | <p>Шүд угаах цагийг ажлын байранд хэрэгжүүлж албан хаагчдыг сургалтад хамруулах</p> | - | <p>Шүд угаах цагийг 2 ажлын байранд хэрэгжүүлж албан хаагчдыг сургалтад хамруулах</p> | <p>Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/71 дугаар тоот тушаалын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан удирдамж, зураглалын дагуу ажлын байранд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгож орон нутгийн 165 албан хаагч, нийслэлийн ЧД-ийн 18 хэлтэс хороо, онцгой байдлын хэлтсийн 115 албан хаагч нар өртөөчилсөн сургалт зохион байгуулсан</p> | <p>2025.03-05</p> <p><i>Анх дээрх мэдээлэл өгснөөр</i></p> | <p>100%</p> <p><i>14</i></p> |


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Дуусах хугацаа |
|-----|----------------------------------|------------------|--------------|-----------------|-------------------------|----------------|
| | | | | Эхний хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | |
| | | | | | | |

| | | | | | Эхлэх, дуусах хугацаа | | |
|----|--|---|---|---|---|---------------|------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байх | - | Богино хугацааны сургалтад сурсан байна | Удирдлагын академийн "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт"-ад хамрагдаж төгссөн. | 2025.04.14-25 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2.2. Докторын сургалтын арга аргачлалыг батлуулах | Арга аргачлал батлуулах хурлын протокол | - | - | Арга аргачлалыг батлуулсан байна | 2025.06-12 | Хугацаа болоогүй |

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчний амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Номин /  /

2025.06.10